



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны
үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан**



**Компанийн хуримтлагдсан
алдагдлын хэмжээ өссөөр байна**

Улаанбаатар хот
2017 он

АГУУЛГА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ҮАГ/ГАГ/2016/09-ГА

Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
М.Наранжаргал

Чиглэлийн аудитын албаны аудитын менежер:
Д.Баттулга

Ахлах аудитор Б.Болормаа
Ахлах аудитор Ж.Эрдэнэ

Аудитор М.Доржмаа
Шинжээч С.Одонцэцэг
Ш.Наранбаатар
Г.Мөнхчимэг
И.Туяадарь

2017 оны 2 дугаар сар

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 263755, 262451 дугаарын утсаар харилцана уу.

Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү. /www.audit.mn/

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3,
Засгийн газрын IV байр
Улаанбаатар хот 15160

▪ Товчилсон үгийн жагсаалт	2
▪ Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
▪ Тайлангийн хураангуй	4
Бүлэг 1. Компанийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт хүчин чадлын хэмжээнд төлөвлөгдөөгүй, зарим бүтээгдэхүүний үнэ буурсан байна	5
▪ Техник, эдийн засгийн зарим үзүүлэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.....	5
▪ Тайлант хугацаанд компанийн үндсэн бүтээгдэхүүний үнэ буурсан үзүүлэлттэй байна.....	5
Бүлэг 2. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна	7
▪ Ашигт малтмалын олборлолт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна	7
▪ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	7
▪ Төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй байна	8
▪ Эргэлтийн хөрөнгө дутагдалтай байгаагаас зарим тоног төхөөрөмжийг бараа солилцоогоор авсан байна.....	9
Бүлэг 3. Хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй нь компанийн үнэ цэнийг бууруулж байна	
▪ Биет бус хөрөнгөд бодит үнэ цэнийн хэмжилт хийгдээгүй байна....	10
▪ Хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна	10
▪ Үндсэн бус үйл ажиллагааны зардал алдагдал үүсгэж байна.....	11
▪ “Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах ажлын явц хангалтгүй байна	12
▪ Өглөг, авлагыг барагдуулах талаар зохиосон ажил үр дүнд хүрээгүй байна.....	12
▪ Зарим сангийн хөрөнгийг батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулжээ.....	14
▪ Татвар хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.....	15
▪ Тайлант хугацаанд өмчлөгчдийн хөрөнгөд ногдох ашиг хуваарилаагүй байна.....	16
▪ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.....	16
Бүлэг 4. Нөхөн сэргээлтийг төлөвлөсөн хэмжээнд хийгээгүй, зарим ашигт малтмалын ордыг бүрэн ашиглаагүй байна	
▪ Засгийн газар нөхөн олговорт хууль тогтоомж зөрчин хайгуулын тусгай зөвшөөрөл олгожээ	17
▪ Зарим уурхайн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл хангалтгүй байна.....	18
▪ “Бор-Өндөр” уулын баяжуулах үйлдвэр байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж байна.....	19
▪ Дүгнэлт	20
▪ “Монголросцветмет” ХХК-иас ирүүлсэн санал.....	21
▪ Зөвлөмж	22
▪ Хавсралт №1.....	23
▪ Хавсралт №2.....	24
▪ Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал.....	25

Товчилсон үгийн жагсаалт

АМГ	Ашигт малтмалын газар
ААН	Аж ахуйн нэгж
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНХС	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГУУЯ	Геологи, уул уурхайн яам
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОХУ	Оросын Холбооны Улс
СЯ	Сангийн яам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УБУ	Уулын баяжуулах үйлдвэр
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХБ	Худалдаа хөгжлийн банк
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХН	Хязгаарлалттай хариуцлагатай нийгэмлэг

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандартын талаарх мэдэгдэл

“Монголросцветмет” ХХК-ийн 2014-2016 оны 3 дугаар улирлын байдлаарх үйл ажиллагааны үр дүнд аудит хийж дүгнэлт өгч, дүн дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулан УИХ-ын Төсвийн байнгын хороо болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Аудитыг дараах чиглэлээр гүйцэтгэлээ. Үүнд:

- Компани үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг үр ашигтай төлөвлөсөн эсэх;
- Компани үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулсан эсэх;
- Үйл ажиллагааны үр дүнг бодитой бүртгэж тайлагнасан эсэх;
- Хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх

Аудитаар “Монголросцветмет” ХХК, түүний харьяа “Бор-Өндөр” УБҮ салбар цехүүд, “Зэрэгцээ” алтны уурхай, үйлдвэрүүд болон эдгээр байгууллагуудын 2014-2016 оны 3 дугаар улирлын байдлаарх үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, худалдан авах үйл ажиллагааны тайлан, бараа, материал, үндсэн хөрөнгийн тайлан, бусад холбогдох баримт бичгүүдийг хамруулсан.

3. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан “Монголросцветмет” ХХК-ийн удирдлага болон холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, судалгаа тодруулга авах, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийв.

4. Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг УАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газрын дарга М.Наранжаргал удирдаж, Чиглэлийн аудитын албаны менежер Д.Баттулга чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Болормаа, Ж.Эрдэнэ, аудитор М.Доржмаа, шинжээч С.Одонцэцэг, Ш.Наранбаатар, Г.Мөнхчимэг, И.Туяадарь нар гүйцэтгэлээ.

5. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл

Аудитын тайлан нь тайлангийн хураангуй, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт гэсэн агуулгаар үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

6. Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

“Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам, гэрээ хэлэлцээр, бизнес төлөвлөгөө болон холбогдох бичиг баримтууд төрийн албан ёсны хэл буюу монгол хэл дээр үйлдэгдээгүй байсан нь цаг хугацаа алдах хүндрэл учруулж байв.¹

¹ Монгол улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцаж, санхүү, татвар, хөдөлмөрийн холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтөлнө.

Тайлангийн хураангуй

БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1973 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн Хэлэлцээрийн (цаашид “Хэлэлцээр” гэх) дагуу “Монголросцветмет” аж ахуйн нэгдлийг (цаашид “Компани” гэх) байгуулсан байна.

Уг Хэлэлцээрийг Монгол Улсын Их Хурлын 2009 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн тогтоолоор соёрхон баталсан байна.

Компанийн удирдах дээд байгууллага нь Компанийн зөвлөл буюу Талуудын төлөөлөгчдөөс бүрдэх Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх) байна гэж Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заажээ.

Компанийн хувь нийлүүлсэн өмчийн 51 хувийг Монгол Улсын Засгийн газар, 49 хувийг Оросын Холбооны Улсын Төрийн өмчит “Ростех” корпораци эзэмшиж байсан бөгөөд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар өмчлөгч өөрчлөгдсөн талаарх албан ёсны мэдээлэл компанид алга байна.

Компанийн үйл ажиллагааны тухай Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд “Зөвлөлийн хурлыг ... жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна” гэж заасан боловч 2014, 2015 онд 48 болон 49 (эчнээ) дүгээр хуралдааныг тус тус зохион байгуулж, 2016 онд Зөвлөл хуралдаагүй байна.

Компани жилд 610.0 мянган тонн жоншны хүдэр олборлож, 600.0 мянган тонн хүдэр боловсруулж, 120.0 мянган тонн ФФ-95 маркийн флотацийн баяжмал, 12.0 мянган тонн ФК-75 маркийн металлургийн баяжмал үйлдвэрлэх, 2.0 сая тонн төмрийн хүдэр олборлож, 450.0 мянган тонн хүдэр боловсруулж, 200.0 мянган тонн 52 хувийн агуулгатай хуурай, 250.0 мянган тонн 65 хувийн нойтон агуулгатай төмрийн баяжмал үйлдвэрлэх хүчин чадалтай байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар жоншны 13, алтны 6, мөнгө 4, холимог металлын 1, төмрийн 1, зэсийн 1, нийт хайгуулын 4, ашиглалтын 26 тусгай зөвшөөрөл бүхий 17.0 сая тонн жоншны хүдрийн, 16.2 сая тонн төмрийн хүдрийн, 1.4 тонн алтны нөөцтэй байна. (Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаар харуулав)

Тус компанийн бүрэлдэхүүнд Улаанбаатар хот дахь захиргаа, “Бор-Өндөр” УБҮ, түүний харьяа салбар цехүүд, “Зэрэгцээ” алтны уурхай, ОХУ-ын Москва хот дахь төлөөлөгчийн газар, БНХАУ-ын Эрээн хот дахь салбар нэгжид 1397 ажиллагсад ажиллаж байна.

2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд 27,396.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 1,604.3 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 24,271.0 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Тус байгууллагын хуримтлагдсан алдагдал 9,562.6 сая төгрөг байна.

Аудитаар нийт 16,303.8 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг арилгуулах талаар хугацаатай акт, албан шаардлага бичигдсэн ба зохион байгуулалтын 2, хууль журмыг хэрэгжүүлэх 4, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 3, нийт 9 зөвлөмж өглөө.

Мөн өр, авлагын барагдуулалт болон байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой нийт 2,573.8 сая төгрөгийн үр өгөөжийг тодорхойлж, аудитын хугацаанд холбогдох албан тушаалтанд танилцуулж баталгаажуулсан болно.

Бүлэг 1. Компанийн үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт хүчин чадлын хэмжээнд төлөвлөгдөөгүй, зарим бүтээгдэхүүний үнэ буурсан байна

Техник-эдийн засгийн зарим үзүүлэлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна

1.1 Компанийн үйл ажиллагааны тухай Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд “Зөвлөлийн хурлыг ... жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна” гэж заасан боловч 2014, 2015 онд 48 болон 49 (эчнээ) дүгээр хуралдааныг тус тус зохион байгуулж 2016 онд Зөвлөл хуралдаагүй байна.

1.2 Дээрх зөвлөлийн хуралдаанаар компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг *үйлдвэрлэл, эдийн засаг, татвар, ашиг хуваарилалт, хүний нөөц* зэрэг үзүүлэлтээр баталжээ. Үйлдвэрлэлийн үндсэн хүчин чадлыг тайлант онуудын батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулан хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №1

Бүтээгдэхүүний нэр төрөл	Хэмжих нэгж	Хүчин чадал	2016 оны III улирал		2015 он		2014 он	
			төлөв	хувь	төлөв	хувь	төлөв	хувь
Жоншны хүдэр олборлолт	мян.тн	610.0	133.5	21.9	146.8	24.1	200.0	32.8
Жоншны хүдэр боловсруулалт	мян.тн	600.0	115.7	19.3	163.9	27.3	183.7	30.6
Жоншны баяжмал үйлдвэрлэлт	мян.тн	132.0	34.0	25.7	48.6	36.8	48.0	36.3
Төмрийн хүдэр олборлолт	мян.тн	2000.0	1350.0	67.5	848.7	42.4	1000.0	50.0
Төмрийн хүдэр боловсруулалт	мян.тн	900.0	535.2	59.4	430.6	47.8	867.8	96.4
Төмрийн баяжмал үйлдвэрлэлт	мян.тн	450.0	223.8	40.6	189.0	34.6	442.8	80.5
Элс угаалт	м3	1000.0	876.0	87.6	846.0	84.6	91.0	9.1
Уулын цул шилжүүлэлт	м3	1600.0	474.0	29.6	1431.5	89.5	1766.0	110.4

Эх сурвалж: Компанийн 2014-2016 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт

1.3 Компани өөрийн нөөц, хүчин чадлыг үндэслэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт үзүүлэлтэд хүргэж төлөвлөөгүй нь тайлант онуудад уламжлалт хэрэглэгчид, түүний харьяа зарим үйлдвэрүүд хаагдаж, дэлхийн зах зээл дээрх жонш болон төмрийн хүдрийн эрэлт буурсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд компанийн үндсэн бүтээгдэхүүний үнэ буурсан үзүүлэлттэй байна

1.4 Компанийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.3.10²-т заасны дагуу компани өөрийн үйл ажиллагаагаа төлөвлөх, үйлдвэрлэх бүтээгдэхүүнийхээ хэмжээ, өөрийн өртгийг тодорхойлох, борлуулалтын үнийг тогтоох эрхтэй байна.

1.5 Дэлхийн зах зээл дээрх жоншны баяжмалын болон төмрийн хүдрийн үнэ тайлант хугацаанд буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал,

2010 онд 1 тонн жоншны баяжмал 521 ам.доллар байсан бол 2016 онд 200 орчим ам.доллараар буурсан байна.

²Өөрийн үйл ажиллагааг төлөвлөх, үйлдвэрлэх бүтээгдэхүүнийхээ хэмжээ, өөрийн өртгийг тодорхойлох, түүнчлэн борлуулалтын үнээ тогтоох.

1.6 Компанийн борлуулсан бүтээгдэхүүний үнийг дэлхийн зах зээлийн дундаж үнэтэй харьцуулан хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №2 (ам.доллар)

Бүтээгдэхүүний нэр	Дэлхийн зах зээлийн дундаж үнэ*	Борлуулалтын дундаж үнэ	Зөрүү
2016 оны III улирал			
ФФ-95 флотацийн баяжмал	255.4	321.4	66
ФК-75 металлургийн баяжмал	241.3	144.6	-96.7
Fe-65 төмрийн баяжмал	47.3	45.3	-2
Fe-52 төмрийн баяжмал	37.4	25.6	-11.8
2015 он			
ФФ-95 флотацийн баяжмал	288.4	315.9	27.5
ФК-75 металлургийн баяжмал	196.9	167.2	-29.7
Fe-65 төмрийн баяжмал	60.1	52.6	-7.5
Fe-52 төмрийн баяжмал	41.7	31.2	-10.5
2014 он			
ФФ-95 флотацийн баяжмал	309.5	308	-1.5
ФК-75 металлургийн баяжмал	196.9	166	-30.9
Fe-65 төмрийн баяжмал	101.1	85	-16.1
Fe-52 төмрийн баяжмал	72.9	47	-25.9

*Эх сурвалж: СЯ болон АМГТГ-ын сайтад байршуулсан экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний зах зээлийн үнийн мэдээлэл

1.7 Ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1.4³ -т заасны дагуу экспортод гаргасан зарим бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнийг баримтлан тогтоож чадаагүй байна.

1.8 Компани эцсийн хэрэглэгчидтэй бүтээгдэхүүн борлуулах гэрээ байгуулахдаа барааг төмөр замын ачих талбайд хүлээн авах, буулгах, хадгалах, шилжүүлэн ачих, тээвэрлэх зэрэг нэмэлт зардлыг тооцож ашигтай төлбөрийн нөхцлийг сонгодог байна.

³ Уурхайн эдэлбэрээс олборлосон ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлийн үнээр борлуулах”

Бүлэг 2. Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын үр дүн хангалтгүй байна

Ашигт малтмалын олборлолт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна

2.1 Компани бизнес төлөвлөгөөтэй уялдуулан уулын ажлын төлөвлөгөө боловсруулдаг ба 2014 оны төлөвлөгөөг 2015 оныхтой харьцуулахад жонш олборлолт 24.5 хувь, төмөр 49.0 хувиар тус тус буурсан байна. Тайлант оны ашигт малтмалын олборлолтын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №3

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2016.09.30			2015 он			2014 он		
		төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь
Жонш	мян.тн	133.5	105.3	78.9	146.8	148.3	101.0	200.0	153.0	76.5
Төмөр	мян.тн	1350.0	630.4	46.7	848.7	786.4	92.7	1000.0	436.7	43.7
Алт	кг	77.9	58.8	75.5	89.2	89.6	100.0	69.4	79.4	114.4

2.2 Дээрх хугацаанд жонш 406.6 мянган тонн, төмөр 1853.5 мянган тонн, алт 227.5 килограммыг олборлож батлагдсан төлөвлөгөөг 81 орчим хувиар биелүүлсэн байна.

2.3 2016 оны 3 дугаар улирлын байдлаар төмрийн хүдэр 46.7 хувь, жоншны олборлолт 78.9 хувьтай байгаа нь зарим худалдан авсан тоног төхөөрөмж чанаргүй, үйлдвэрийн гологдол, техникийн эвдрэл гарсан, дизель түлш хугацаандаа нийлүүлэгдээгүй, үйлдвэрлэлийн сул зогсолтоос шалтгаалсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн хэрэгжилт хангалтгүй байна

2.4 Зөвлөлийн 2013-2014 онуудын ээлжит хуралдаанаар батлагдсан бизнес төлөвлөгөөний дагуу дараах худалдан авалтыг хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөсөн худалдан авалтын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №4 (сая төгрөг)

Худалдан авалт	2016.09.30			2015 он			2014 он		
	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь
Тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл	2,488.9	2,205.2	88.6	2,699.4	3,405.7	126.2	3,955.6	1,757.2	44.4
Сэлбэг хэрэгсэл	2,368.5	1,548.6	65.4	1,644.3	1,384.2	84.2	1,701.7	701.3	41.2
Бараа материал	8,685.3	3,831.0	44.1	7,364.2	4,264.0	57.9	6,627.8	4,524.1	68.3
Тэсрэх бодис	395.3	196.6	49.8	529.6	266.8	50.4	569.7	195.4	34.3
Хүнд даацын дугуй	1,135.8	232.7	20.5	515.2	377.7	73.3	640.6	130.2	20.3
Шатах тослох материал	8,240.1	3,444.4	41.8	6,715.6	5,101.2	76.0	7,703.0	4,913.8	63.8
Нүүрс	593.1	752.1	126.8	850.3	957.9	112.7	968.4	948.8	98.0
Нийт	23,906.7	12,210.6	51.1	20,318.6	15,757.4	77.6	22,166.8	13,170.8	59.4

2.5 Компанийн гүйцэтгэх удирдлагын баталсан 2014-2016 оны “Худалдан авалтын төлөвлөгөө”-нд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 50.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар төлөвлөжээ. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №5 (сая төгрөг)

Он	Төлөвлөсөн		Зарлагдсан								Зарлагдаагүй	
			Бүгд		Үүнээс			Шууд гэрээ		Хүчингүй		
	Тоо	Дүн			Тоо	Дүн	Тоо					Дүн
			Тоо	Дүн				Тоо	Дүн	Тоо	Дүн	
2016	56	28,381.9	24	15,908.6	4	1,936.3	12	3,198.3	8	10,774.0	32	12,473.3
2015	33	16,716.1	32	16,052.0	4	1,501.6	14	4,537.2	14	10,013.2	1	664.1
2014	47	15,780.1	13	10,114.0	1	433.4	12	5,705.3	0	3,975.3	34	5,666.1
Нийт	136	60,878.1	69	42,074.6	9	3,871.3	38	13,440.8	22	24,762.5	67	18,803.5

2.6 Хүснэгтээс харахад тайлант хугацаанд 136 худалдан авах ажиллагааг зарлахаар төлөвлөсөн бөгөөд 49 хувьд нь бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажиллагаа хийгдээгүй байна.

2.7 Харин 69 арга хэмжээнд худалдан авах ажиллагааг нээлттэй явуулснаас 9 хүчинтэй, 22 хүчингүй, 38-д үнийн харьцуулалт хийж шууд гэрээ байгуулсан байна. Тухайлбал,

- 2014 онд 428.2 сая төгрөгийн ган бөмбөлөг, 724.6 сая төгрөгийн 2 тонн баяжмалын уут, 2,927.5 сая төгрөгийн дизель түлш, 301.4 сая төгрөгийн мазут;
- 2015 онд 373.6 сая төгрөгийн ган бөмбөлөг, 225.4 сая төгрөгийн аммиак, 2,020.6 сая төгрөгийн дизель түлш;
- 2016 онд 75.1 сая төгрөгийн автомашины дугуй, 186.6 сая төгрөгийн ган бөмбөлөг, 307.1 сая төгрөгийн “Драг”-ын сэлбэгийг тус тус худалдан авчээ.

2.8 Цаашид бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй байна

2.9 Компани жонш, төмрийн хүдэр, алтны уурхайд шинээр техник, тоног төхөөрөмж худалдан авах, хуучин техник хэрэгсэлд их засвар хийх, үйлдвэр болон зарим цех хэсгүүдэд нэмэлт шинэчлэл хийх, байгууламж байгуулах зорилгоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж Зөвлөлийн 2014 оны 48, 2015 оны 49 дүгээр хуралдаанаар батлуулсан байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №6 (сая төгрөг)

Хөрөнгө оруулалтын төрөл	2016 он		2015 он		2014 он	
	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
Барилга, тоног төхөөрөмж	1,653.7	52.0	2,857.5	-	1,405.8	-
Их засвар	1,503.6	-	1,732.2	198.5	1,435.0	77.5
Нийт дүн	3,157.3	52.0	4,589.7	198.5	2,840.8	77.5

2.10 Дээрх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг он тус бүрээр гаргахад ажлын гүйцэтгэл хангалтгүй, төлөвлөгөө биелэгдээгүй байна.

2.11 Компани жонш, төмрийн хүдрийн олборлолтыг нэмэгдүүлэх, борлуулах зорилгоор өөрийн дотоод нөөц бололцоог ашиглан уулын нэвтрэлтийн ажил, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, засвар хийх ажилд 2014-2016 онуудад хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй 7,799.2 сая төгрөгийн нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2014 онд 87.3 сая төгрөгийг “Бор-Өндөр” УБҮ-ийн далд уурхайн нэвтрэлтийн ажилд, 97.2 сая төгрөгийг төмөр замын цехэд авто ачигч SL-50w худалдаж авахад, 862.6 сая төгрөгийг хуурай соронзон баяжмалын хэсэгт, 102.1 сая төгрөгийг их засварын ажилд;
- 2015 онд 4,412.0 сая төгрөгийг экскаватор, автосамосвал, ачигч, бойлор зэрэг машин тоног төхөөрөмжид, 172.5 сая төгрөгийг уулын ажилд, 143.6 сая төгрөгийг их засварын ажилд;
- 2016 онд Баргилтын цехэд нийт 1,793.3 сая төгрөгийг машин, компрессор, өрөм зэрэг тоног төхөөрөмж, 128.7 сая төгрөгийг их засварын ажилд тус тус зарцуулсан байна.

2.12 Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн бодитой боловсруулах, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Эргэлтийн хөрөнгө дутагдалтай байгаагаас зарим тоног төхөөрөмжийг бараа солилцоогоор авсан байна

2.13 Зарим тоног төхөөрөмж, шатах тослох материалыг 2014-2016 онуудад төмрийн болон жоншны баяжмалаар солилцож авсан байна. Тухайлбал,

- 1553.4 тонн төмрийн баяжмалаар “Erlan Boeing Trade” компаниас 133.6 мянган ам.долларын үнэ бүхий баяжмалын уут болон техникийн содыг;
- 906.9 тонн төмрийн баяжмалаар “RuiXiangTongJing” компаниас 78.0 мянган ам.долларын үнэ бүхий баяжмалын уутыг;
- 6545.0 тонн 32 хувийн агууламжтай төмрийн баяжмалаар “Жэй Эм Эс Си” ХХК-иас 261.8 сая төгрөгийн үнэ бүхий дизель түлшийг;
- 1690.1 тонн төмрийн баяжмалаар “Азтүлхүүр” ХХК-иас 120.0 мянган ам.долларын үнэ бүхий тосны хүчлийг;
- 1292.0 тонн жоншны баяжмалаар “Литейщик” компаниас 413.4 мянган ам.долларын үнэ бүхий тээрэм болон бутлуурын доторлогооны ган хуягийг;
- 47427.0 тонн 52 хувийн агууламжтай төмрийн баяжмалаар “Erenhot Pengfei Trade” компаниас 1,470.2 мянган ам.долларын үнэ бүхий автомашины сэлбэг, автогрейдер, самосвал автомашиныг;
- 1206.8 тонн жоншны баяжмалаар “Литейщик” компаниас 386.2 мянган ам.долларын үнэ бүхий дизель түлшээр солилцоо хийсэн байна.

2.14 Тоног төхөөрөмж болон бараа материалаар бартер хийхдээ компаниас тогтоосон үнэтэй нийцүүлэн дундажаар 1 тонн төмрийн баяжмалыг 86 ам.доллараар, 1 тонн жоншны баяжмалыг 320 ам.доллараар тооцсон байна.

Бүлэг 3. Хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй нь компанийн үнэ цэнийг бууруулж байна

Биет бус хөрөнгөд бодит үнэ цэнийн хэмжилт хийгдээгүй байна

3.1 Компанийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд нийт 62,607.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 24,271.0 сая төгрөгийн эргэлтийн, 38,336.8 сая төгрөгийн эргэлтийн бус хөрөнгө байна.

3.2 Биет бус хөрөнгөд бүртгэлтэй тусгай зөвшөөрөлтэй ордуудын нөөцийн үлдэгдлийг ашигт малтмалын төрлөөр үзүүлбэл,

Хүснэгт №7 (мян.тн)

Үлдэгдэл нөөц	Жонш	Төмөр	Зэс	Холимог металл				Алт
				мөнгө	зэс	сурьма	висмут	
Хүдэр	17029.8	16174.9	1909.2	6.4				2270.3 мян.м3
Эрдэс	6346.5	5594.9	14.1	2.2	72.6	31.8	3.3	1.47 тн

- **Баргилтын төмрийн ордын хүдрийн нөөцийг 9.1 сая тонн, эрдсийн нөөцийг 3.4 сая тонноор баталсан⁴ байна. 2011 оны ТЭЗҮ-д ашиглалтын үеийн хүдэр олборлолтыг 18.0 сая тонн, төмрийн хүдрийн баяжмалыг 7.8 сая тонноор 9 жил ашиглахаар тооцсон ба 2015 оны жилийн эцсийн байдлаар хүдрийн 16.2 сая тонн, эрдсийн 5.6 сая тонн нөөцийн үлдэгдэлтэй;**
- **Хөх дэл жоншны ордын эрдсийн нөөцийг 574.8 тонноор баталсан⁵ бөгөөд 2011 оны ТЭЗҮ-д хүдэр олборлолтыг 454.1 мянган тонноор 8 жил ашиглахаар тооцсон ба 2015 оны жилийн эцсийн байдлаар хүдрийн 1044.7 мянган тонн, эрдсийн 381.1 мянган тонн нөөцийн үлдэгдэлтэй;**
- **Бор-Өндөрийн хайлуур жоншны ордын хүдрийн нөөцийг 10485.5 мянган тонн, эрдсийн нөөцийг 34014.7 мянган тонноор баталсан⁶ байна. 2010 онд ТЭЗҮ шинэчлэн 437.5 мянган тонн хүдрийн нөөцийг жилд 110.0 мянган тонноор олборлож 5 жил ашиглахаар тооцсон ба 2015 оны жилийн эцсийн байдлаар хүдрийн 3495.7 мянган тонн, эрдсийн 1217.4 мянган тонн нөөцийн үлдэгдэлтэй;**
- **Улаан уулын алтны шороон ордын алтны нөөцийг 121.0 кг-аар шинэчлэн бүртгэсэн⁷ бөгөөд 2013 оны ТЭЗҮ-д 115.8 кг алт олборлож, 2 жил ашиглахаар тооцсон байна. 2015 оны жилийн эцсийн байдлаар 38 кг алтны нөөцийн үлдэгдэлтэй;**
- **Туул голын гольдролын алтны шороон ордын алтны үлдэгдэл нөөц 2013 оны байдлаар⁸ 1529.5 кг байгаа бөгөөд 2016 оны ТЭЗҮ-д 973.8 кг алт олборлон, 7 жил ашиглахаар тооцсон;**
- **Асгатын мөнгө-холимог металлын ордын мөнгөний нөөцийг 976 тонн, зэс 32.8 мянган тонн, сурьма 13.4 мянган тонн, висмут 1.8 мянган тонноор баталсан⁹ байна. Үйлдвэр байгуулах техник, эдийн засгийн урьдчилсан тооцоо, судалгааг олон улсын мэргэжлийн байгууллагуудаар хийлгэсэн;**
- **Хараат зэсийн ордын хайгуулын ажилд 1.9 тэрбум төгрөг зарцуулж, зэсийн хүдрийн нөөцийг 1.9 сая тонн, эрдсийн нөөцийг 14.1 мянган тонноор баталсан¹⁰ бөгөөд 2013 оны ТЭЗҮ-д жилд дундажаар 237.9 мянган тонн зэсийн хүдэр олборлон, 4 жил ашиглахаар тооцсон байна.**

3.3 Нийт хөрөнгийн 43.7 хувийг үндсэн хөрөнгө, 21.1 хувийг бараа материал, 9.0 хувийг татвар, НДШ болон авлага, 8.2 хувийг урьдчилж төлсөн зардал, 18.0 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Хөрөнгийн дахин үнэлгээ хийгдээгүй байна

3.4 2008 оноос хойш компанийн үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна. Тухайлбал,

- Компанийн хэмжээгээр 4,468.5 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үл хөдлөх хөрөнгө;
- “Бор-Өндөр” УБҮ-ийн баяжуулах фабрикийн 6,582.3 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгө, нийт 11,050.8 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлээгүй байна.

3.5 Үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг дахин үнэлгээ хийлгэснээр компанийн хөрөнгийг бодитой үнэлэх, хувь

⁴ АМГ-ын даргын 2010 оны “Нөөц хүлээн авч, бүртгэх тухай” 993 дугаар тушаал

⁵ АМГТХЭГ-ын даргын 2008 оны “Нөөц хүлээн авч, бүртгэх тухай” 75 дугаар тушаал

⁶ 1983 оны БНМАУ болон ЗСБНХУ-ын Улсын нөөцийн Комиссын хуралдааны тэмдэглэл

⁷ АМГ-ын даргын 2011 оны “Нөөц хүлээн авч, бүртгэх тухай” 227 дугаар тушаал

⁸ АМГ-аас “Монголросцветмет” ХХК-д ирүүлсэн 2015 оны Б/7554 дүгээр албан бичгээр

⁹ 1996 оны Эрдэс баялгийн зөвлөлөөр

¹⁰ АМГ-ын даргын “Нөөц хүлээн авч, бүртгэх тухай” 2012 оны 224 дүгээр тушаал

нийлүүлсэн хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

3.6 “Бор-Өндөр” УБҮ-т хамаарах Дорноговь аймгийн Өргөн суманд байршиж буй ил уурхайн үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор ашиглалтын хугацаа дууссан 3,040.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 261.6 сая төгрөгийн сэлбэг, 60.2 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгааг эргэлтэд оруулах талаар албан шаардлага хүргүүлсэн болно.

3.7 Засгийн газрын 2013 оны 391 дүгээр тогтоолоор “Бор-Өндөр” УБҮ-ийн балансад байгаа ундны эх үүсвэрийн 4 худаг, дагалдах байгууламжийг “Монгол Ус” ТӨҮГ-ын балансад шилжүүлэх шийдвэр гарсан боловч ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

3.8 Уг асуудал шийдвэрлэгдээгүйгээс 2014 оноос 2016 оны 9 дүгээр сарын байдлаар 2,884.8 сая төгрөгийн ашиглалтын зардал гарсан байна.

Үндсэн бус үйл ажиллагааны зардал алдагдал үүсгэж байна

3.9 Компанийн 2014, 2015, 2016 оны 3 дугаар улирлын үндсэн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус орлого, зарлагын үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал,

Үзүүлэлт	Хүснэгт №8 (сая төгрөг)		
	2016 оны III улирал	2015 он	2014 он
Борлуулалтын орлого:	40,852.3	57,256.4	56,233.0
Борлуулсан нийт бүтээгдэхүүний өртөг	40,454.8	55,824.4	55,170.8
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал	397.5	1,431.9	1,062.2
Орлого	2,400.7	3,462.7	2,519.3
Зардал	12,353.1	13,755.6	13,677.8
Үйл ажиллагааны бус орлого зарлагын дүн	-9,952.4	-10,293.0	-11,158.6
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-9,554.9	-8,861.1	-10,096.4
Татварын зардал	7.7	1.3	-996.9
Татварын дараах ашиг/алдагдал	-9,562.6	-8,862.3	-9,099.5

3.10 Компани 2014 онд 9,099.4 сая, 2015 онд 8,862.3 сая, 2016 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 9,562.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

3.11 Компани борлуулалт, маркетинг болон удирдлагын зардалд 2014 онд 9,973.5 сая, 2015 онд 10,806.8 сая, 2016 оны 3 дугаар улиралд 8,287.6 сая, нийт 29,067.9 сая төгрөг зарцуулсан байна.

3.12 Харин үндсэн бус үйл ажиллагаанаас 2014-2016 оны 3 дугаар улирлын байдлаар өссөн дүнгээр 8,382.7 сая төгрөгийн орлого олж 39,786.5 сая төгрөгийн зардал гаргасан байна.

3.13 Энэ нь Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын цахилгаан, дулааны шугам сүлжээний ашиглалтын зардал, Төв аймгийн Заамар сумын Өгөөмөр тосгоны уурын зуух, цэвэр бохир усны зардалд нилээд хөрөнгө зарцуулсантай холбоотой байна.

3.14 Гадаад валютаар авсан зээл, зээлийн хүү болон байгуулсан гэрээнүүд дарамт болж, валютын ханшийн зөрүүнээс 2014 онд 5,441.6 сая, 2015 онд 2,583.9 сая, 2016 оны 3 улиралд 4,882.3 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

“Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах ажлын явц хангалтгүй байна

3.15 2012 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хуралдсан “Монголросцветмет” ХХК-ийн Зөвлөлийн 46 дугаар хурлаас “Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах шийдвэр гарсан байна. “Монголросцветмет” ХХК-ийн Ерөнхий захирлын 2013 оны “Татан буулгах тухай” бпр, “Хавсран ажиллах тухай” 121пр дүгээр тушаалаар “Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах комиссыг томилсон боловч төлөвлөгөөт ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.

3.16 “Шижир алт” ХХК-ийн хөрөнгийн нийт 2,996.2 сая төгрөгийн авлага бүртгэлтэй боловч санхүүгийн тайланд 929.0 сая төгрөгийн авлагыг баталгаажуулаагүй, өглөгөөр бүртгээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

3.17 “Шижир алт” ХХК-ийн эзэмшлийн уул уурхайн тоног төхөөрөмжүүдийг “Зэрэгцээ” алтны уурхай болон “Бор-Өндөр” УБҮ-тэй түрээсийн гэрээ байгуулан 1,743.3 сая төгрөгийн зардал гаргасныг бүртгэсэн байна.

Өглөг, авлагыг барагдуулах талаар хэрэгжүүлсэн ажил үр дүнд хүрээгүй байна

3.18 Компанийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд 65,519.7 сая төгрөгийн богино хугацаат, 12,575.6 сая төгрөгийн урт хугацаат, нийт 78,095.3 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №9 (сая төгрөг)					
№	Өглөгийн төрөл	2016.09.30	2015.12.31	2014.12.31	2013.12.31
1	Улсын болон орон нутгийн төсөвт төлөх татвар, төлбөр	7,870.7	7,560.9	5,519.5	2,469.4
2	Нийгмийн даатгалын өглөг	5,455.1	3,723.8	1,850.2	947.5
3	Арилжааны банкны зээл, зээлийн хүү	20,862.2	20,226.8	18,473.3	17,247.8
4	Урт хугацаат өр төлбөр	25,049.1	21,147.7	19,046.8	12,248.6
5	Цалингийн өглөг	1,582.0	1,763.9	1,829.1	2,774.9
6	Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	12,957.5	12,683.4	8,773.5	9,897.1
7	Бусад өглөг	4,318.3	6,508.0	4,198.6	6,728.5
	Нийт	78,095.2	73,614.8	59,691.2	52,313.8

3.19 Хүснэгтээс үзэхэд өр төлбөрийн хэмжээ 2013 оны түвшингээс 25,781.0 сая төгрөгөөр өссөн нь валютын ханшийн зөрүү, арилжааны банкны зээлийн хүү, ус ашигласны төлбөр, бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөрийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.20 Эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар зээл авах асуудлыг компанийн Зөвлөл шийдвэрлэж, ТӨХ-ны тухайн үеийн удирдлагуудын зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- ТӨХ-ны даргын 2012 оны 1а/951 тоотоор¹¹ ОХУ-ын “Галополимер Пермь” ХХН-тэй байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг барьцаалж Голомт банкинд 2.0 сая ам.долларын зээлийн шугам нээхийг;
- ТӨХ-ны даргын 2012 оны 1а/2377 тоотоор¹² хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг төлөх зорилгоор нийт 3.8 сая ам.долларын зээлийг “Ростех” корпорациас авахыг;
- ТӨХ-ны даргын 2013 оны 1а/3680 тоотоор¹³ Худалдаа хөгжлийн банктэй байгуулсан тус бүр нь 2.0 сая ам.долларын хоёр зээлийг нэгтгэн 4.0 сая ам.долларын зээл болгон хугацааг сунгуулахыг тус тус зөвшөөрсөн байна.

¹¹ “Монголросцветмет” ХХК-ийн Ерөнхий захирлын “Зээлийн шугам нээх тухай” 2012 оны 5 дугаар сарын 9-ны өдрийн 1/871 тоот бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэсэн.

¹² “Монголросцветмет” ХХК-ийн Ерөнхий захирлын “Зээл авах тухай” 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 1/904 тоот бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэсэн.

¹³ “Монголросцветмет” ХХК-ийн Ерөнхий захирлын “Зээлийн шугам нээх тухай” хүсэлт

3.21 Өр төлбөрийн асуудлыг шийдвэрлэх талаар Зөвлөл хангалтгүй ажилласан байна.Тухайлбал,

- 2015 онд эчнээ хуралдсан Зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу улсын төсөвт төлөх бүх төрлийн татварын өрийн асуудлыг шийдвэрлэх, татварын хөнгөлөлт эсвэл өршөөлд хамруулах, татварын өр төлөлтийн хугацааг хойшлуулах буюу урт хугацаагаар татварын тогтвортой байдлын гэрээ байгуулах замаар асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хувьцаа эзэмшигчдэд албан захидал хүргүүлсэн¹⁴ боловч ОХУ-ын талаас харуу ирүүлээгүй;
- “Монголросцветмет” ХХК болон “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хооронд байгуулсан MR-2007-07-72 дугаар гэрээний дагуу үүссэн өр төлбөрийг данснаас хасах талаар асуудал боловсруулахыг талуудын удирдлагад үүрэг болгосон боловч нэгдсэн шийдэлд хүрээгүй байна.

3.22 Энэ нь “Компанийн дүрэм”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6.14-т заасны дагуу Зөвлөл компанийн алдагдлыг хаах асуудлаар тодорхой шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

3.23 Компанийн өр зээлийн хэмжээ жил бүр нэмэгдэж, эдийн засаг, санхүүгийн хувьд дампуурлын эрсдэлд орсон нь дараах байдлаас шалтгаалжээ. Үүнд:

- Дэлхийн зах зээл дээр үйлдвэрлэлийн гол бүтээгдэхүүн болох жонш болон төмрийн хүдрийн баяжмалын үнийн уналт үргэлжилж байгаагаас борлуулалтын орлого буурсан;
- ОХУ-ын томоохон хэрэглэгчид хэрэгцээгээ багасгаж, бүтээгдэхүүний үнэ болон эрэлт буурсан нөхцөлд үндсэн үйлдвэрлэлд сул зогсолт гарах, үйлдвэрлэлийг зайлшгүй хязгаарласан;
- Санхүүгийн менежментийн дутагдалтай байдлаас татварын өр төлбөр, авлага ихээр үүссэн;
- Валютын ханшийн зөрүүнээс гадаад валютаар авсан зээл, зээлийн хүү дарамт болж, алдагдал нэмэгдэж санхүүгийн хүндрэлд орсон байна.

3.24 Компанийн хэмжээнд өр төлбөр үүссэн асуудал дараах нөхцөл, шалтгаантай байна.Үүнд:

- Бор-Өндөр УБУ-ийн тоног төхөөрөмжийн иж бүрэн шинэчлэлд зориулж 2007 онд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-иас авсан 5.5 сая ам.долларын зээл 2015 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс төлж эхлэх хуваарьтай боловч эргэн төлөлт хийгдэж эхлээгүйгээс ханшийн өсөлтөөр 12.5 тэрбум төгрөгт хүрсэн;
- Худалдаа хөгжлийн банкнаас 2012 онд эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зориулалтаар 3.0 сая ам.доллар, 2013 онд 4.0 сая ам.долларын зээлийг тус тус жилийн 13.8 хувийн хүүтэй авсан байна. Тус компанийн хүсэлтийн дагуу ХХБ-ны Зээлийн хорооны хурлын 591 тоот шийдвэрээр уг хоёр зээлийг нэгтгэж “Зээлийн нэмэлт гэрээ”¹⁵-г байгуулж, компанийн бүх борлуулалтын орлого, авлага, харилцах дансны үлдэгдэл, олборлосон шоншны баяжмал, төмрийн хүдрийг барьцаалсан байна. 2016 оны 09 дүгээр сарын байдлаар зээлийн үлдэгдэл 5.6 сая, зээлийн хүү 217.1 мянган ам.доллар байна¹⁶.
- 2012 онд Голомт банкнаас жилийн 15 хувийн хүүтэй авсан 4.0 сая ам.долларын зээлийн үлдэгдэл 3.9 сая ам.доллар бөгөөд эргэн төлөлт 2017 оны 6 дугаар сараас эхлэнэ;
- Компанийн хувьцаа эзэмшигч нарт 2011 оны ногдол ашиг төлөх зорилгоор “Ростех” корпорациас 2012 онд авсан жилийн 13 хувийн хүүтэй 3.8 сая ам. долларын зээлийн эргэн төлөлт 2014 оны 3 дугаар сараас эхлэсэн;
- Нийт 246 бэлтгэн нийлүүлэгчдээс “Магнай Трейд Баянгол” ХХК-д 1.4 тэрбум, “НИК” ХХК-д 1.8 тэрбум, “Багануур-Зүүн Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-д 1.7 тэрбум төгрөг, “М-Ойл” ХХК-д 465.9 сая төгрөгийн өр нэмэгдсэн байна.

3.25 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх авлагын хэмжээ 2014 оныхтой харьцуулахад 3.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. Хүснэгтээр харуулбал,

“Монголросцветмет” ХХК-ийн авлагын насжилтийн байдал

Хүснэгт №10 (сая төгрөг)

Харилцагч	2016.09.3	2015 он	2014 он	2013 он	2012 он	2011 он
Үндсэн харилцагч	3,813.3	2,283.5	721.1	91.1		
ААН, байгууллага	406.3	238	189.2	5.1	6.3	

¹⁴ ЗГХЭГ-аас №ХЭГ/741 дүгээр албан бичгээр Сангийн сайд, Уул уурхайн сайд нарт асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулахыг үүрэг болгосон.

¹⁵ 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн №ЗГ/230-1 тоот “Зээлийн нэмэлт гэрээ”.

¹⁶ Зээлийн эргэн төлөлт 2015 оны 01 дүгээр сарын 27-ноос эхлэсэн

Ажиллагсад, хувь хүмүүс	175.1	169.7	110.2	13.9	14.1	12.5
Нийт дүн	4,394.7	2,691.2	1,020.5	110.1	20.4	12.5

3.26 Дээрх хүснэгтээс үзэхэд компанийн авлагыг бууруулах, нэмж бий болгохгүй байх тал дээр ахиц гараагүй, зарим гадаадын байгууллагаас авах авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Тухайлбал,

- Бүтээгдэхүүний борлуулалттай холбоотой ОХУ-ын “Галополимер Пермь” ХХН 1,620.1 сая, “Магнитогорск” металлургийн үйлдвэр 862.2 сая, “Мария трейд” ХХН 201.9 сая, БНХАУ-ын “Erlan Xinfuyan trading” Co.Ltd 439.4 сая, “Erenhot city Zhongtian” Co.Ltd зэрэг харилцагчдаас 214.5 сая төгрөгийн авлагатай;
- БНХАУ-ын нэр бүхий 7 компанийн 101.4 сая, ОХУ-ын нэг компанийн 34.0 сая, нийт 135.5 сая төгрөгийн авлагыг тайлант хугацаагаар тасалбар болгон тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.27 Аудитаар тайлант хугацааны эцэст авлага үүсгэхгүй байх, улирал тутам харилцагч байгууллагатай авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулах талаар албан шаардлага өглөө.

Зарим сангийн хөрөнгийг батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулжээ

3.28 Компанийн гүйцэтгэх удирдлага “Ажиллагсдын байдлын тухай журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.20¹⁷ -т заасны дагуу материаллаг урамшууллын сан, нийгмийн хөгжлийн санг жил бүр баталдаг ба сангуудаас 1,616.8 сая төгрөгийг зарцуулсныг доорх хүснэгтээр харуулбал,

Хүснэгт № 11 (сая төгрөг)

Сангууд	2016 оны III улирал			2015 он			2014 он		
	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц	Хувь
Материаллаг урамшууллын сан	335.0	309.7	85.4	240.6	245.2	101.9	420.0	143.6	34.1
Нийгмийн хөгжлийн сан	488.0	317.4	69.0	392.2	358.0	91.2	520.0	242.9	46.7
Дүн	823.0	627.1	-	634.1	603.2	-	940.0	386.5	-

3.29 Сангуудын зарцуулалтыг сан тус бүрээр нэгтгэн авч үзэхэд дүнгээрээ хэмнэгдэж буй боловч зарим төрлийн зардал төлөвлөгөөнөөс 64.2 сая төгрөгөөр хэтэрсэн байна. Тухайлбал,

Хүснэгт №12 (сая төгрөг)

Үзүүлэлт	2016 оны III улирал			2015 он			2014 он			
	төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	зөрүү	төлөв	гүйц	Зөрүү	
Материаллаг урамшууллын сан	Нэг удаагийн тусламж	-	-	-	-	-	-	120.0	129.8	9.8
	Ажиллагсдын хоолны хөнгөлөлт	-	-	-	51.3	52.7	1.4	22.0	33.6	11.6
	Баяр, ёслол тэмдэглэх	-	-	-	33.1	57.4	24.3	50.0	51.5	1.5
	Орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах	-	4.5	4.5	-	-	-	-	6.2	6.2
	Хандив тусламж	-	1.1	1.1	-	-	-	-	1.1	1.1
	Эрүүл мэндийн зардал	-	-	-	3.0	5.2	2.2	-	-	-
	Бусад	-	-	-	1.6	2.1	0.5	-	-	-
	Нийгмийн хөгжлийн сан	Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсны урамшуулал	-	-	-	-	-	-	50.0	55.8
Тэмдэглэлт ой, тэтгэвэрт гарсны урамшуулал		-	-	-	56.1	56.3	0.2	-	-	-
Шагнал урамшуулал		-	-	-	7.9	17.8	9.9	-	-	-
Ажлын үр дүн болон онцгой үүрэг гүйцэтгэсний урамшуулал		150.0	248.7	98.7	-	-	-	-	-	-

¹⁷“Ажлын онцгой үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд ажилтнуудад урамшуулал олгоно.”

3.30 Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн компанийн захиргаа болон харьяа уурхайн зарим ажиллагсад 2014 онд 4,312.8 сая, 2015 онд 4,384.4 сая, 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 4,047.9 сая, нийт 12,745.3 сая төгрөгөөр илэрхийлэгдсэн ам.долларын нэмэгдэл цалин олгожээ.

3.31 Тус компанийн Ерөнхий захирлын нэгдүгээр орлогчид “Хөдөлмөрийн гэрээ”-ний дагуу 2014-2016 онд цалин хөлсөд 808.0 сая, орон сууцны түрээсийн төлбөрт 62.0 сая, нийт 870.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.32 Мөн 2013-2015 оны Зөвлөлийн хурлын шийдвэр, хөдөлмөрийн гэрээний дагуу чөлөөлөгдсөн гүйцэтгэх удирдлагад нийт 322.4 мянган ам.долларын нэмэгдэл урамшуулал, нөхөн олговор олгосон байна.

3.33 Компани алдагдалтай ажиллаж буй тохиолдолд валютын цалингийн нэмэгдэл болон бусад төрлийн нөхөн олговор олгохыг түр зогсоох нь зүйтэй юм.

3.34 Зөвлөлийн 2012 оны 46 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн Ерөнхий захирлын 2016 оны 20-р дугаар тушаалаар ажлын үр дүн болон онцгой үүрэг биелүүлсний шагналд 220.6 сая төгрөгийн өртөг бүхий таван орон сууцыг нэр бүхий ажилтнуудад үнэгүй олгосныг материаллаг урамшууллын санд оруулан тооцсон байна.

Татвар хураамжийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна

3.35 Компанийн бизнес төлөвлөгөөнд улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, шимтгэл, төлбөр, хураамжийг жил бүр тооцож Зөвлөлөөр батлуулдаг байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №13 (сая төгрөг)

Он	Татвар, хураамжийн төсөвт төвлөрүүлэх дүн /сая төг/		Нийт дүн
	Улсын	Орон нутгийн	
2016	3,548.9	4,845.6	8,394.5
2015	3,318.7	4,206.9	7,525.6
2014	5,120.9	5,858.8	10,979.7
Дүн	11,988.5	14,911.3	26,899.8

3.36 2014-2016 онд нийт 26,899.8 сая төгрөгийн татвар төлөхөөр тооцоолсон ба төлөх татвар, шимтгэл дараах үлдэгдэлтэй байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт №14 (сая төгрөг)

Албан татварын төрөл	Эцсийн үлдэгдэл		
	2016 оны III улирал	2015 он	2014 он
НДШ/шимтгэл	6,612.0	3,723.8	1,850.2
АМНАТ / жонш /	1,604.9	1,918.6	1,275.3
АМНАТ / төмөр /	4,776.4	3,871.2	2,334.3
Усны төлбөр	965.4	1,576.5	1,252.9
Бусад	524.1	191.5	632.7
НИЙТ ДҮН	14,482.8	11,281.6	7,345.4

3.37 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 6,612.0 сая төгрөгийн НДШ, 6,381.3 сая төгрөгийн АМНАТ, 1,489.3 сая төгрөгийн бусад төлбөр хураамжуудыг төлж барагдуулаагүй байна.

Тайлант хугацаанд өмчлөгчдийн хөрөнгөд ногдох ашиг хуваарилаагүй байна

3.38 Хэлэлцээрийн 15 дугаар зүйлд “...хэлэлцээрээр тогтоосон хэмжээний татварыг төлсний дараа Компанийн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашгийн хэсгийг зөвлөлийн шийдвэрээр хувь нийлүүлэгчдэд Компанийн дүрмийн сан дахь хувь хөрөнгөд нь тэнцүүлэн ногдол ашиг болгон хуваарилах бөгөөд зөвлөлөөс баталсан сан байгуулах журмын дагуу Компанийн сангуудад шилжүүлнэ” гэж заажээ.

3.39 Үүний дагуу компани 2011 онд 8.1 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан тул 6.9 тэрбум төгрөгийг Зөвлөлийн шийдвэрийн дагуу дүрмийн сан дахь хувь хөрөнгөд нь тэнцүүлэн Монгол Улсад 3.5 тэрбум, ОХУ-д 3.4 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тус тус хуваариласан байна.

3.40 Гэвч Зөвлөлийн 2012 оны 45 дугаар хуралдааны шийдвэрээр ногдол ашиг төлөх зорилгоор “Ростех” корпорациас 3.8 сая ам.долларыг жилийн 13.0 хувийн хүүтэй авсан боловч 2016 оны 3 дугаар улирлын байдлаар зээлийн эргэн төлөлт хийгдээгүй бөгөөд зээл, хүүгийн нийт 8,680.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна

3.41 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “...дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна”, 3.1.1-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалтын үйлчлэх хүрээнд “Монголросцветмет” ХХК хамаарч байна.

3.42 Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т “5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг” 6.4.5-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” зэрэг мэдээллийг байршуулаагүй байна.

Бүлэг 4. Нөхөн сэргээлтийг төлөвлөсөн хэмжээнд хийгээгүй, зарим ашигт малтмалын ордыг бүрэн ашиглаагүй байна

Засгийн газар нөхөн олговорт “Ашигт малтмалын тухай хууль” зөрчин хайгуулын тусгай зөвшөөрөл олгожээ

4.1 Компани 2014 оноос хойш хайгуулын 6, ашиглалтын 32 нийт хүчин төгөлдөр 38 тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнийг 2016 оны 3 дугаар улирлын байдлаар харуулбал,

Хүснэгт №15

Орд	Ашиглаж байгаа	Ашиглаагүй	Түр зогссон	Түрээсийн гэрээтэй	Бусдад шилжүүлсэн	АМГ-т		Цуцлагдсан	Шинээр авсан	Бүгд
						Буцаасан	Буцаах шатанд			
Бор-Өндөр	4	1	7	1		3	1			17
Зэрэгцээ	3					2	3		4	12
Бусад ¹⁸		6			1			2		9
Бүгд	7	7	7	1	1	5	4	2	4	38

4.2 Компани 2014-2016 онд тусгай зөвшөөрлийн төлбөрт 580.8 сая төгрөг төлснөөс ашиглаагүй болон түр зогссон, цаашид ашиглах боломжтой, ашигт малтмалын нөөцтэй 14 тусгай зөвшөөрлийн төлбөрт 472.9 сая төгрөг төлсөн байна.

4.3 Иймд дээрх ашиглах боломжтой, ашигт малтмалын нөөцтэй, түр зогссон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар үр ашиггүй зардлыг бууруулах боломжтой юм.

4.4 Компани “Түйн голын эх”, “Түйн гол-3” алтны шороон ордын хайгуулын ажилд 700.0 гаруй сая төгрөгийг зарцуулж, нөөц батлуулсан байна.

4.5 Гэвч Засгийн газрын 2015 оны “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлах, зөвшөөрөл олгох тухай” 359 дугаар тогтоол¹⁹-оор дээрх тусгай зөвшөөрлүүдийг цуцалж, нөхөн олговорт Төв аймгийн Заамар суманд ИТХ-ын саналыг авалгүй, сонгон шалгаруулалтгүйгээр 4 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгож АМТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.13²⁰ дахь заалтыг үндэслэсэн боловч тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4²¹, 19.12²² дахь заалтуудыг зөрчсөн байна.

¹⁸ Асгатын мөнгөний ордын 4, Хяргас нуурын зэсийн орд 1, Өндөр цагааны холимог металлын 1, нийт 6 ордын тусгай зөвшөөрөл

¹⁹ 1-д “Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын нутагт орших Түйн голын алтны шороон ордын XV-003595, XV-004211 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийг цуцлах, нөхөн олговорт зориулж Төв аймгийн Заамар сумын нутагт хавсралтад заасан солбилцлын дагуу ашигт малтмалын ордын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгох”

²⁰ “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр энэ хуулийн 19.12, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно.

²¹ “Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц тухайн талбай байрших сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу өгөх бөгөөд энэ хугацаанд хариу өгөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ”.

²² “Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбайд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгоно”

4.6 Дээрх тусгай зөвшөөрөл бүхий ордуудыг орон нутгийн эсэргүүцэлтэй тулгарсан гэх шалтгаанаар цуцалсан нь батлагдсан нөөцийг 2015 оны 9 дүгээр сарын байдлаарх Монголбанкны алтны дундаж үнээр²³ тооцож үзэхэд 490.1 кг буюу 34.3 тэрбум төгрөг болж байгаа нь компани эдийн засгийн хямралтай байгаа өнөө үед хайгуул хийж нөөц тогтоосон эдийн засгийн ач холбогдол бүхий ордыг ашиглах боломжийг алдсан байна.

4.7 Нөхөн сэргээлт хийгдээгүйгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байгаа ба “Бор-Толгой” 1, “Зэрэгцээ” алтны уурхайн 3, нийт 4 талбай АМГ-т буцаагдахаар хүлээгдэж байгаа бөгөөд тайлант хугацаанд тусгай зөвшөөрлийн төлбөрт 6.6 сая төгрөгийн зардал гарсан байна.

4.8 Компани 2004 онд ХХБ-аас 4878А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг барьцаалан 700.0 сая төгрөгийн зээл авчээ. Уг зээл төлөгдөж дууссан боловч өнөөг хүртэл тусгай зөвшөөрөл нь барьцаанаас чөлөөлөгдөөгүй, АМТХ-ийн 51 дүгээр зүйлийн 51.4²⁴, 51.5²⁵ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.9 Компанийн эзэмшлийн Дорноговь аймгийн Иххэт сумын 19.9 га талбай бүхий Хамар-Усны хайлуур жоншны ил уурхайг ашиглуулахаар “Баянтэгш Импекс” ХХК-тай түрээсийн гэрээ байгуулан ажиллажээ. Аудитаар гэрээний дагуу төлж барагдуулаагүй үндсэн төлбөрийн 16.6 сая, алдангийн 8.1 сая, нийт 24.7 сая төгрөгийн акт бичигдлээ.

Зарим уурхайн нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэл хангалтгүй байна

4.10 Компанийн 2014-2016 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийг уурхай тус бүрээр харуулбал,

Хүснэгт № 16

Он	Ордын нэр	Нөхөн сэргээлт хийсэн талбай (га)						
		Техникийн			Биологийн			Хувь
		төлөв	гүйц	хувь	төлөв	гүйц		
2016 оны III улирал	Зэрэгцээ	50.0	40.0	80.0	30.0	-	-	
	Хөх дэл	1.0	-	0	-	-	-	
	Баргилт	-	-	-	0.2	0.1	29.4	
2015	Зэрэгцээ	45.0	26.5	58.9	30.0	12.1	40.3	
	Хөх дэл	-	-	-	1.0	-	-	
	Баргилт	-	-	-	-	-	-	
2014	Зэрэгцээ	35.0	20.2	57.7	20.0	23.3	116.5	
	Хөх дэл	0.2	0.3	135.0	0.3	0.2	65.6	
	Баргилт	0.2	-	-	-	-	-	

4.11 Дээрх уурхайнуудад техникийн нөхөн сэргээлт 55.3 хувь, биологийн нөхөн сэргээлт 42.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- 2014 онд Баргилтын төмрийн хүдрийн уурхайд 0.2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн боловч санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдалтай холбоотой хийгдээгүй;

²³ “Түйн голын эх, Түйн гол-3 ордуудын батлагдсан нийт нөөц 490.1 кг бөгөөд Монголбанкны 2015 оны 9 дүгээр сарын дундаж үнээр буюу 70.0 сая төгрөгөөр тооцов.

²⁴ “Барьцааны гэрээ дуусгавар болсны дараа тусгай зөвшөөрөл барьцаалсныг бүртгэлээс хасуулах тухай өргөдлийн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараахь баримт бичгийн хамт төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ”.

²⁵ “Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 51.4-т заасан баримт бичгийг хүлээн авсны дараа тусгай зөвшөөрлийн барьцааны гэрээ дуусгавар болсныг бүртгэнэ”.

- 2015 онд “Зэрэгцээ” алтны уурхайн техникийн нөхөн сэргээлтийг 45 га талбайд хийхээр төлөвлөсөн боловч 18.5 га-д хийгдээгүй, 26.6 га-д хийсэн боловч стандартын шаардлага хангаагүй;
- 2016 онд “Зэрэгцээ” алтны уурхайн биологийн нөхөн сэргээлтийг 30 га талбайд хийхээр төлөвлөсөн боловч хийгдээгүй байна.

4.12 Нөхөн сэргээлтийг хийхгүй орхигдуулснаар байгаль орчинд сөрөг нөлөөллийг бий болгох бөгөөд нөхөн сэргээлтийг батлагдсан төлөвлөгөөгөөр стандартын дагуу хийх шаардлагатай байна.

“Бор-Өндөр” УБҮ байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөөгүй үйл ажиллагаа явуулж байна

4.13 Хэлэлцээрийн 13²⁶ дугаар зүйл, Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11²⁷, Засгийн газрын 2013 оны “Журам батлах тухай” 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”-ын 5.1²⁸ дүгээр зүйл, БОНХС-ын 2014 оны А-04 дүгээр тушаалын “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3.1²⁹ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- “Бор-Өндөр” УБҮ өмнөх онуудад ашигласан усны төлбөрийг бүрэн барагдуулаагүй тул Байгаль орчин, аялал жуулчлалын яам байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлаагүй;
- “Зэрэгцээ” алтны уурхайн Туул голын гольдрол төсөл дээр “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ” хийгдээгүйгээс ус ашиглах дүгнэлтгүй, сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулаагүй;
- “Улаан-Уул” төслийн “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-нд тооцоо буруу хийгдсэнээс сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулаагүй үйл ажиллагаа явуулж байна.

4.14 Аудитаар “Бор-Өндөр” УБҮ-ийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах, “Зэрэгцээ” алтны уурхайн ус ашиглах гэрээг байгуулж хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллуулах талаар албан шаардлага хүргүүлээ.

4.15 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 104.6 сая төгрөгийн (өссөн дүнгээр) барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэн боловч буцаалт хийгдээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

²⁶“Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авч, түүний дотор уул уурхайн ажлын улмаас гэмтсэн газрыг нөхөн сэргээх, тохижуулах, мөн байгалийн баялгийг бүрэн дүүрэн цогц ашиглах талаар арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлнэ”

²⁷ “...зөвшөөрлийг үндэслэн ус ашиглах эрхийн бичиг олгож, гэрээ байгуулснаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ус ашиглах эрх үүснэ”

²⁸ “Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө батлуулаагүй, холбогдох баталгааны хөрөнгийг байршуулаагүйгээр төслийн үйл ажиллагааг эхлэх, үргэлжлүүлэх эрхгүй”


²⁹ “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төсөлд хийсэн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, түүнд үндэслэн боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.”

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Компани өөрийн нөөц, үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийг хүчин чадлын хэмжээнд хүргэж төлөвлөөгүй, зарим бүтээгдэхүүний үнийг дэлхийн зах зээлийн үнэд хүргэж тогтоогоогүй байна.
- Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан зарим хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй нь төлөвлөлт, тооцоолол бодитой бус, компанийн санхүүгийн чадавхи буурсан, гүйцэтгэх удирдлагын ажлын зохион байгуулалт хангалтгүй байгаатай холбоотой байна.
- 2008 оноос хойш компанийн хөрөнгийг дахин үнэлээгүй, ашиглах боломжгүй, чанарын шаардлага хангахгүй, хуучирсан техник, тоног төхөөрөмж, бараа материал нийт хөрөнгийн 40 гаруй хувийг эзэлж байна.
- 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд хуримтлагдсан алдагдал 9,562.6 сая төгрөгт хүрсэн нь гадаад валютын зээл, ханшийн зөрүүнээс 4,882.3 сая төгрөгийн алдагдал хүлээж, санхүүгийн хүндрэл үүсэх нэг нөхцөл болсон байна.
- Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн захиргаа болон салбар уурхайн зарим ажиллагсдад 2014-2016 оны 9 дүгээр сарын байдлаар 12,745.3 сая төгрөгтэй тэнцэх ам.долларын нэмэгдэл цалин олгосон байна.
- Компанийн нийт өр төлбөр 78,095.3 сая, авлага 4,394.7 сая төгрөгт хүрсэн нь хөрөнгийг зохистой удирдах, өр авлага үүсгэхгүй байх талаар компанийн гүйцэтгэх удирдлага үр дүнтэй ажиллаагүйг харуулж байна.
- Орон сууц, нийгэм соёлын зориулалттай байгууламжийг орон нутагт шилжүүлэх асуудлыг шийдвэрлээгүйгээс 2,884.8 сая төгрөгийн ашиглалтын зардал гарсан байна.
- Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөц дууссантай холбоотойгоор “Шижир-Алт” ХХК-ийг татан буулгах тухай Зөвлөлийн хурлын шийдвэр 2012 онд гарсан боловч өнөөг хүртэл тодорхой шийдвэрт хүрээгүй байна.
- Байгаль орчны нөхөн сэргээлтийг төлөвлөсөн хэмжээнд хийгээгүй, зарим ашигт малтмалын ордыг бүрэн ашиглах боломжийг алдсан байна.

“Монголросцветмет” ХХК-иас ирүүлсэн санал:


МОНГОЛРОСЦВЕТМЕТ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ
13341 Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 98,
Утас: 45-80-72, Факс: (976-11) 45-83-80, 45-84-30,
E-mail: mailbox@monros.mn; http://www.mongolros.mn


ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БАТТУЯА ТАНАА


2017.01.17, № 1/44
танай _____-ны № _____-т

Тайлангийн төсөлд
санал хүргүүлэх тухай

“Монголросцветмет” ХХК-ийн 2014-2016 оны 3 дугаар улирлын байдлаарх үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг үзэж, танилцаад дараах өөрчлөлтүүдийг хийх саналтай байна. Үүнд:

1. Тайлангийн төслийн хүснэгт №1 төмрийн баяжмалын үйлдвэрлэлийн хүчин чадал 550.0 мян.тн гэснийг “200.0 мян.тн” болгон өөрчлөх;
2. Төслийн 4.10 дахь заалтын тайлбарын 2 дугаар хэсгийг “2015 онд “Зэрэгцээ” алтны уурхайн техникийн нөхөн сэргээлтийг 45га талбайд хийхээр төлөвлөсөн боловч 17.9га талбайд нөхөн сэргээлт хийгдээгүй, 27.1га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэн өгсөн байна.” гэж өөрчлөх;
3. Төслийн 4.10 дахь заалтын тайлбарын 3 дугаар хэсгийг “2016 онд “Зэрэгцээ” алтны уурхайн биологийн нөхөн сэргээлтийг 30га талбайд хийж гүйцэтгэсэн бөгөөд нөхөн сэргээлтийн ажлыг 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн актаар баталгаажуулсан байна.” гэж тус тус өөрчлөх саналтай байна.
4. Төслийн хүснэгт №2 Зах зээлийн үнийн эх сурвалж болох www.indmin.com, www.umetal.com цахим сайтуудад 75%-ийн агуулгатай металлургийн үнэ гэж байдаггүй бөгөөд 80%-с дээш агуулгатай металлургийн баяжмалын үнэ тавигддаг. Манай компанийн үйлдвэрлэдэг ФК-75 маркийн металлургийн баяжмалын үнийг дээрх эх сурвалжид тавигдсан үнэтэй харьцуулахад учир дутагдалтай байгаа тул төслийн 1.8 дахь заалтыг хасах саналтай байна.
5. “Монголросцветмет” ХХК нь “Шилэн дансны тухай” хуулийн үйлчлэх хүрээний 3.1.3-т хамаарагдаж байгаа бөгөөд уг хуулийн 6.8-д заасны дагуу 5 төрлийн мэдээллийг шилэн дансны мэдээлэлд цаг тухайд нь байршуулан ажиллаж байгаа тул төслийн 3.42 дахь заалтыг хасах саналтай байна.
6. Аудитын тайлангийн 4.7 дахь заалтад тусгагдсан асуудал нь гүйцэтгэлийн аудит хийх хугацаанд хамаарагдахгүй байгаа тул тус зүйл заалтыг хасах саналтай байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  Д.ГАНБОЛД



0066

Тайлбар 1-ийг үзнэ үү.
Тайлбар 2-ыг үзнэ үү.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

Тайлбар 5-ыг үзнэ үү.

Тайлбар 6-г үзнэ үү.

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

- | | |
|-----------|--|
| Тайлбар 1 | Нотлох баримтыг үндэслэн хүснэгтэд №1-т төмрийн хүдрийн баяжмал боловсруулах хүчин чадлыг 450.0 мянган тонн болгон өөрчлөлт оруулав. |
| Тайлбар 2 | Нөхөн сэргээлтийг актаар баталгаажуулаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй. |
| Тайлбар 3 | Аудитын хамрах хүрээний хугацаанд биологийн нөхөн сэргээлтийг хийгээгүй тул саналыг хүлээн авах боломжгүй. |
| Тайлбар 4 | Хүснэгт №2-ийн мэдээллийн эх сурвалжийг өөрчлөв. |
| Тайлбар 5 | Саналыг хүлээн авах боломжгүй. |
| Тайлбар 6 | Тухайн асуудлын үр дагавар нь аудитын хамрах хугацаанд хамаарч байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй. |

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

“Монголросцветмет” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Алдагдалтай ажиллаж байгаа нөхцөлд валютын нэмэгдэл цалин болон нөхөн олговор олгож байгааг зогсоох.
2. Үндсэн хөрөнгөд дахин үнэлгээ хийж, ашиглагдахгүй байгаа хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.
3. “Шижир-Алт” ХХК-ийг үндсэн компанид нэгтгэх асуудлыг шийдвэрлэх.
4. Нийгмийн чиглэлийн зориулалттай зарим объектуудыг орон нутагт шилжүүлэх, худалдан борлуулах, эргэлтэд оруулах зэрэг асуудлыг судлан шийдвэрлэх.
5. Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн бодитой боловсруулан батлах, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.

“Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагад:

1. Бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад зах зээлийг судлах ажлыг өргөжүүлэх замаар үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлэх.
2. Экспортод гаргах үндсэн бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн үнийг баримтлан борлуулж байх, шинэ зах зээлийг судлах.
3. Улс орон нутгийн төсөвт төлөх татвар хураамж, авлага, банкны зээлийг төлж барагдуулах талаар тодорхой арга хэмжээг авч, хэрэгжүүлэх.
4. Дотоодын худалдан авалт, эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийг дотоодын мөнгөн тэмдэгтээр тооцож гэрээ байгуулан ажиллах.
5. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг стандартын дагуу бүрэн гүйцэтгэж, зарим ашигт малтмалын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судлан шийдвэрлэх.
6. 2004 онд 4878А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг барьцаалан Худалдаа хөгжлийн банкнаас авсан зээлийн барьцааны гэрээг дуусгавар болгож АМТХ-ийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

Компанийн эзэмшлийн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн судалгаа

№	ТЗ*-ийн дугаар	Байршил		Ордын нэр	Талбайн хэмжээ (га)	Ашигт малтмалын төрөл	2015 оны эцсийн үлдэгдэл нөөц /мян.тн/		Тайлбар	
		Аймаг	Сум				Балансын хүдэр	Балансын эрдэс		
1	MV-000164	Дорноговь	Өргөн	Өргөн	8.4	Жонш	326.3	165.3	Ашиглах боломжтой	
2	MV-013440			8-р хүдрийн бүс	34.8		36.9	11.4		
3	MV-012884			Өргөн	35.5		3493.9	1481.6		
4	MV-000160		Их хэт	Баруун баргын овоо	Баруун баргын овоо		6.9	659.1	261.3	Түрээсийн гэрээтэй
5	MV-000159				Хамар ус		19.9	298.3	127.9	
6	MV-011722				Зүүн цагаан дэл		141.8	4399.5	1481	
7	MV-000163				Бужгар		14.1	214.4	104.2	
8	MV-000161		Айраг	Бор-Толгой	Бор-Толгой		5.6	-	-	АМГ-т буцаах
9	MV-000174				Бор-Өндөр Дархан		Бор-Өндөр	371.4	3495.7	
10	MV-000173		Хэнтий	Бор-Өндөр	Адаг		69.3	2741.8	1003.8	Ашиглах боломжтой
11	MV-011425				7,18,19,20-р хүдрийн биет		167.9	319.2	111.6	
12	MV-004487		Дундговь	Баянжаргалан	Зүүн үнэгт		92.5	1044.7	381	
13	MV-004306				Төв үнэгт		92.4			
Дүн							17029.8	6346.5		
14	MV-000278	Баян-Өлгий	Ногоон нуур	Асгат	2.4	Мөнгө	6.4	Мөнгө-2.2 Зэс-72.6 Сурьма-31.8, Висмут-3.3	Ашиглах боломжтой	
15	MV-004388			Асгатын орд	37					
16	MV-008191			Асгатын өмнөд участок	390.2					
17	MV-008645	Хэнтий	Өмнөдэлгэр Дархан	Асгатын хойд төвийн хэсэг	620.6	Холимог металл	-	-		
18	MV-011721			Өндөр цагаан-1	665.8					
19	MV-016657	Увс	Наранбулаг	Баргилт	133	Төмөр	16174.8	5594.8	Ашиглах боломжтой	
20	MV-018900			Хяргас нуур	7260.7	Зэс	1909.1	14.1		
21	MV-000175	Булган, Төв	Бүрэгхангай, Заамар	Туул голын гольдрол	503.4	Алт	2187.7	1.43		
22	MV-007137			Улаан уул	113.2		79.8	0.04		
23	MV-004878	Төв	Заамар	Улаан уул	66.4	Алт	2.7	0.002	Ашиглах боломжтой	
24	MV-010875			Улаан уул-2	30		-	-		
25	MV-012131			Цагаан галт	32.5		-	-	АМГ-т буцаах	
26	MV-007197			Туулын баруун дэнж	49.5		-	-		
Дүн							2270.3 мян.м3	1.47 тн		
27	XV-020520	Төв	Заамар	Цагаан галт	554.6	Алт	-	-		
28	XV-020521			Галтын талбай	1885.1		-	-		
29	XV-020523			Урт сайр	144.8		-	-		
30	XV-020580			Хашаат овоот даваат	2585.6		-	-		

*MV-ашиглалтын тусгай зөвшөөрөл, XV-хайгуулын тусгай зөвшөөрөл
Эх сурвалж: АМГ-аас авсан мэдээлэл /2016 оны 11 дүгээр сарын байдлаар/

Компанийн 2014 оноос 2016 оны 9 дүгээр сарын байдлаарх техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 оны III улирал		2015 он		2014 он	
			Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
Зөвлөлөөр батлагдсан үзүүлэлтүүд:								
1	Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	34.0	25.5	44.4	41.7	48.0	41.7
2	Флотацийн баяжмал ФФ-95	мян.тн	26.2	22.2	33.7	31.2	40.0	27.7
3	Металлургийн баяжмал ФК-75	мян.тн	7.8	3.3	10.7	10.5	8.0	14.0
4	Төмрийн хүдрийн бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	223.8	168.6	211.8	202.8	442.8	156.8
5	Fe-65% баяжмал	мян.тн	109.2	68.5	85.8	86.8	131.3	123.7
6	Fe-52% баяжмал	мян.тн	114.6	100.1	125.9	115.9	311.5	33.1
7	Төмрийн хүдрийн борлуулалт	мян.тн	1350.0	477.2	677.1	341.8	428.2	203.1
8	Алт олборлолт	кг	77.9	58.8	89.2	89.6	69.4	79.4
9	Цэвэр ашиг /ашиг, алдагдал/	сая төгрөг	1,084.7	-9,562.6	-9,717.0	-8,862.3	3,225.5	-9,099.4
10	Төсөвт төлөх татвар, шимтгэл	сая төгрөг	4,525.4	3,408.5	2,867.2	3,829.9	10980.4	5,474.7
Тооцооллын үзүүлэлтүүд:								
1	Хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мян.тн	34.0	21.0	48.5	49.5	48.0	38.7
2	Төмрийн хүдрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	мян.тн	148.6	98.6	189.0	167.6	442.8	198.7
3	Хүдэр олборлолт /хайлуур жонш/	мян.тн	133.5	105.3	146.8	148.2	200.0	153.0
4	Хүдэр олборлолт /төмрийн хүдэр/	мян.тн	1350.0	630.4	848.7	786.4	1000.0	436.7
5	Уулын нэвтрэлтийн ажил	т.метр	1320.0	1046.5	1049.3	1112.0	1412.0	918.0
6	Хөрс хуулалт	мян.м3	1672.5	360.8	2,387.4	2321.9	3836.0	2841.9
7	Таваарын бүтээгдэхүүний борлуулалт	сая төгрөг	71,664.6	40,852.3	63,112.2	58,629.1	96,143.3	57,313.7
8	Таваарын бүтээгдэхүүн	сая төгрөг	70,886.9	39,021.5	62,807.5	59,094.3	89,593.3	60,082.8
9	Таваарын бүтээгдэхүүний өртөг	сая төгрөг	63,206.1	39,265.3	59,913.6	56,400.8	83,442.5	56,676.8
10	1 төгрөгт ногдох таваарын бүтээгдэхүүний зардал	төгрөг	0.89	1.0	0.95	0.95	0.93	0.94
11	Ажиллагсдын дундаж тоо	хүн	1451	1366	1287	1300	1399	1281
12	Цалингийн сан	сая төгрөг	14,670.9	12,663.2	15,107.4	15,593.4	17,129.3	15,007.6
13	Ажиллагсдын сарын дундаж цалин	мянган төгрөг	1,116.2	1,034.3	978.4	999.3	1,012.1	962.8
14	Ажиллагсдын сарын дундаж цалингийн өсөлт	хувиар	106.1	107.1	101.6	103.8	145.5	95.1
15	Хөдөлмөрийн бүтээмж /бүтээгдэхүүн үйлдвэрлэлтээр/	мянган төгрөг/хүн	13,663.5	8,569.4	5,245.5	4,826.7	7,587.4	4,686.0



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн 19.3.3 дахь заалт, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.39 дэх заалт, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Монголросцветмет" ХХК-ийн 2014-2016 оны 9 дүгээр сарын байдлаарх үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, "Монголросцветмет" ХХК-д тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Монголросцветмет" ХХК-ийн Ерөнхий захирал Д.Ганболдод зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор (М.Наранжаргал)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дүгээр тушаалын хавсралт
 А/13

02
 ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт
 УХА0122

“Монголросцветмет” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар илрүүлсэн төлбөр, зөрчлийн жагсаалт

(тегрөгөөр)

№	Хариуцах албан тушаалтан, байгууллагын нэр	Төлбөр, зөрчлийн товч утга	Төлбөр, зөрчлийн дүн	Үүнээс		Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах ажилтны овог, нэр, албан тушаал
				Акт	Албан шаардлага		
1	“Монголросцветмет” ХХК-ийн Ерөнхий захирал Д.Ганболд	Өглөг, авлагыг баталгаажуулах тухай	1,064,500,351.1		1,064,500,351.1	2017.12.15	Ахлах аудитор Б.Болормаа
2		Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгө, бараа материалыг эргэлтэд оруулах асуудлыг шийдвэрлүүлэх	14,412,824,500.0		14,412,824,500.0	2017.12.16	Ахлах аудитор Б.Болормаа
3		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах, усны төлбөрийг барагдуулах	801,782,580.0		801,782,580.0	2017.10.01	Шинжээч С.Одонцэцэг
4		Түрээсийн гэрээний төлбөрийг төлж барагдуулах	24,675,598.0		24,675,598.0		
Нийт дүн			16,303,783,029.1	24,675,598.0	16,279,107,431.1		

Үндэсний аудитын газар